

ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВИЙН  
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 10 сарын 20 өдөр

Дугаар A/36

Улаанбаатар хот

Зарим үйлчилгээнд тариф тогтоох тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн А/35 тоот тушаалаар баталсан “Төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллагаас үйлчилгээ үзүүлэх журам”-ын 10 дугаар зүйлийн 10.1, 10.2, 10.3, төвийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.5.15, дах заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас ирүүлсэн 2022 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 03/1600 тоот албан бичгийн дагуу “Төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллагаас үйлчилгээ үзүүлэх журам”-ын хүрээнд тус төвөөс үзүүлж буй үйлчилгээний үнэ, тарифыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Дээрх үйлчилгээний үнэ, тарифыг 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гурав. Тус төвөөс үйлчилгээ авч буй хуулийн этгээдүүдэд мэдэгдэл хүргэн ажиллахыг Систем нэгтгэлийн хэлтэс/Ө.Гантулга/, Мэдээллийн технологийн хөгжүүлэлтийн хэлтэс /Э.Баттөр/-т, үйлчилгээний гэрээ шинэчлэн байгуулахыг Захиргаа, төлөвлөлтийн хэлтэс /Ц.Ган-Эрдэнэ/-т тус тус даалгасугай.

Дөрөв. Үйлчилгээний холбогдох төлбөрийг тогтоосон хугацаанд Улсын төсөвт төвлөрүүлэхийг Нягтлан бодогч /Д.Сүглэгмаа/-д үүрэг болгосугай.

Тав. Энэ тушаал гарсантай холбогдуулан холбогдох үйл ажиллагааг удирдан зохион байгуулахыг Захиргаа, төлөвлөлтийн хэлтэс /Б.Дагвасүмбэрэл/-д даалгасугай.

ЗАХИРАЛ

М.БАТТУЛГА



“Үндэсний Дата Төв” УТҮГ-ын захирлын  
2022 оны 10 сарын 20-ны өдрийн  
тоот тушаалын хавсралт

**Төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллагаас үзүүлэх  
үйлчилгээний үнэ,тариф**

9020011093-5323394

**1. Төрийн байгууллагад домэйн нэр олгох үйлчилгээ**

Үйлчилгээний нэр	Хэмжих нэгж	Хугацаа	Үнэ₮
Төрийн байгууллагад домэйн нэр олгох үйлчилгээ	1 домэйн	Жил	44,000₮

**2. Төрийн байгууллагын цахим шуудангийн хаяг олгох үйлчилгээ**

Үйлчилгээний нэр	Хэмжих нэгж	Хугацаа	Үнэ₮
Төрийн байгууллагын цахим шуудангийн хаяг олгох үйлчилгээ	1 мэйл хэрэглэгч	Жил	22,000₮

**3. Төрийн байгууллагын цахим хуудас байршуулах үйлчилгээ**

Үйлчилгээний нэр	Хэмжих нэгж	Хугацаа	Үнэ₮
Төрийн байгууллагын цахим хуудас байршуулах үйлчилгээ	1 хостинг /3GB/	Жил	55,000₮

**4. Төрийн байгууллагын мэдээллийн сан байршуулах үйлчилгээ**

Үйлчилгээний нэр	Хэмжих нэгж	Хугацаа	Үнэ₮
Төрийн байгууллагын мэдээллийн сан байршуулах үйлчилгээ	1Core/CPU/	Сар	234,000₮
Холболтын хураамж/нэг удаагийн/			2,250,000₮

**5. Интернэтийн дотоод харилцан холболтын үйлчилгээ**

Үйлчилгээний нэр	Хэмжих нэгж	Хугацаа	Үнэ₮
Интернэтийн дотоод харилцан холболтын үйлчилгээ	Холболтын төрөл/порт/	Сар	200,000₮
Холболтын хураамж/нэг удаагийн/			2,000,000₮

**6. Зогсуур түрээсийн үйлчилгээ**

Үйлчилгээний нэр	Хэмжих нэгж	Хугацаа	Үнэ₮
Зогсуур түрээсийн үйлчилгээ	1 UNIT	Сар	50,000₮
Нэмэлт үйлчилгээ IP хаяг	5,000₮		